

**Н.ГАНТУЛГА**

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор, хурандаа

Цахим шуудангийн хаяг:

gantulga.n@leu.gov.mn
n.gantlga@yahoo.com

**Н.БАТДОРЖ**

ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн ахлах багш, хууль зүйн магистр, хошууч

Цахим шуудангийн хаяг:

batdori.n@leu.gov.mn

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХ ЯЛЫГ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ИНСТИТУЦИ

Хураангуй

Эрдэм шинжилгээний энэ нийтлэлд Монгол Улсын Засгийн газраас санаачлан энэ цаг үед Улсын их хурлаар хэлэлцэж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх журмыг¹ үндэсний хууль тогтоомжийн түүхэн уламжлал,

хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээ, ОХУ, Казахстан улсын Ял эдлүүлэх хууль, олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалттай харьцуулж судлаачийн байр суурийг илэрхийлсэн.

Түлхүүр үг

Насанд хүрээгүй хүн, ялтан, хоригдол, хорих ял, хүмүүжил-хөдөлмөрийн колони, хорих байгуулга /анги/, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, түр, удаан хугацааны уулзалт, чөлөө зэрэг.

Бүтэц

Удиртгал, гурван дэд хэсэг², судлаачийн дүгнэлт-саналаас бүрдэнэ.

Удиртгал

Хүүхдийн³ эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах, баталгаатай эдлэх орчин нөхцлийг бүрдүүлэх, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил гаргасан, түүний золиос болсон, халдлагад өртсөн тохиолдолд "тусгай журам"-аар хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх явдал үндэсний төдийгүй олон улсын эрх зүйн шинжлэх ухаан, эрх зүйн зохицуулалтын чухал объект⁴ болон төлөвшин хөгжиж байна.

² 1-р дэд хэсэг "Үндэсний эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал, өнөөгийн байдал", 2-р дэд хэсэг "Олон улсын гэрээний болон ОХУ, Казахстан Улсын Ял эдлүүлэх хуулийн холбогдох зохицуулалтын онцлог", 3-р дэд хэсэг "Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх зохицуулалт"

³ Цаашид "насанд хүрээгүй хүн" гэх.

⁴ Манай оронд өнөөдөр энэ харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Мэргэжлийн боловсролын тухай, Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх зэрэг хууль, нэгдэн орсон, соёрхон баталсан Монгол Улсын олон улсын гэрээ (хойно нарийвчлан дурьдах болно) болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх бусад актаар зохицуулж байна. Мөн энэ асуудал Үндсэн хуулийн эрх зүй, гэр бүлийн эрх зүй, нийгмийн хамгааллын эрх зүй, захиргааны эрх зүй, захиргааны процесс, эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, криминологи, криминалистик, шүүх сэтгэц зүй, эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй, эрх зүйн

¹ УИХ-ын Хууль зүйн байнгын хороо 2015 оны 05-р сарын 13-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар шийдвэрлэсэн. //www.gonews.mn. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжив"-2015 оны 5-р сарын 25-ны өдрийн хандалт.

Мөн монгол төрийн энэ асуудлаархи бодлого жилээс жилд дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай уялдан тодорхойлогдож, зохицуулалт нь нарийвчлагдаж, салбарын үндэсний мэргэшсэн судлаач эрдэмтэд⁵, мэргэжилтнүүд⁶ олширч байгааг тэмдэглэх ёстой.

Хүүхдийн эрх шинжлэх ухааны судалгаа, зохицуулалтын олон талтай, өргөн хүрээтэй объект учраас нийтлэлийн хүрээнд гагцхүү насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх

1. үндэсний хууль тогтоомжийн түүхэн уламжлал, өнөөгийн байдал,

2. олон улсын эрх зүйн болон гадаад зарим орон /ОХУ, Казахстан Улс/-ны зохицуулалт,

3. УИХ-аар хэлэлцэж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх журмын онцлогийг тодотгон судлаачийн байр суурийг илэрхийллээ.

харьцуулсан судлал, олон улсын нийтийн эрх зүй зэрэг шинжлэх ухааны салбар, салбар дундын судалгааны объект болно.

⁵ ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академид Б.Болдбаатар (Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэж буй хулгайн гэмт хэрэг, М. 2004), Ц.Амгаланбаяр (Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэж буй гэмт хэргийн талаарх эрүүгийн бодлого), МУИС-д түшиглэн байгуулсан хууль зүйн салбараар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд Д.Бадам (Насанд хүрээгүй хүнд ял оногдуулах онцлог, түүний эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал /хорих ялын жишээн дээр/ УБ. 2013), ОХУ-ын ДЯЯ-ны Москвагийн их сургуульд Ю.Бадамханд (Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт халдлагаас хамгаалах криминологийн асуудал" М. 2013 он) нар доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалсан.

⁶ Хүүхдийн байцаагч, нийгмийн ажилтан, мэргэшсэн өмгөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нэгэнт бий болсон, зарим нь бий болох, төлөвших практик тогтжээ.

I

Манай орны хувьд насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх эрх зүйн зохицуулалт салбарын хуульд 1966-1993 онд нийтлэг хэм хэмжээ болон бие даасан "бүлэг"-ийн⁷, харин 1994 оноос нийтлэг, тусгай хэм хэмжээний түвшинд⁸ журамлагдан хэрэгжиж ирсэн.

Мөн хөндөж буй асуудлаархи эдгээр хуулийн дараах онцлог, түүхэн уламжлалыг дурьдаж болно. Энэ нь:

1. Салбарын 1966 оны хуульд "хоригдол"⁹, "хорих ял шийтгүүлсэн этгээд"¹⁰, 1982 оны хуульд "ялтан"¹¹, "хорих ял эдэлж байгаа ялтан"¹², 1993 оны хуульд "хоригдол"¹³, 1996 оны

⁷ БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1966 оны хуулийн 9-р зүйл, 11-р зүйл, 14-р зүйл, 20-р зүйл, 21-р зүйл, 22-р зүйл, 5-р бүлэг /Хүмүүжил-хөдөлмөрийн колони/-ийн 33-37-р зүйл, мөн хуулийн 53-р зүйл, 54-р зүйл, 55-р зүйл, БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1982 оны хуулийн 11-р зүйл, 17-р зүйл, 23-р зүйл, 27-р зүйл, 31-р зүйл, 33-р зүйл, 36-р зүйл, 37-р зүйл, 38-р зүйл, 49-р зүйл, 51-р зүйл, 53-р зүйл, 54-р зүйл, 13-р бүлэг /Хүмүүжил-хөдөлмөрийн колони/-ийн 70-74-р зүйл, мөн хуулийн 106-р зүйл, 113-р зүйл, 115-р зүйл, 116-р зүйл.

⁸ Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай 1993 оны хуулийн 6-р зүйл, 14-р зүйл, 19-р зүйл, 22-р зүйл, 23-р зүйл "Насанд хүрээгүй хоригдол", 30-р зүйл, 34-р зүйл, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай 1996 оны хуулийн 72-р зүйл, 77-р зүйл, 79-р зүйл, 81, зүйл, 82-р зүйл "Насанд хүрээгүй хоригдол", 91-р зүйл, 95-р зүйл, 97-р зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуулийн 105-р зүйл, 107-р зүйл, 110-р зүйл "Насанд хүрээгүй ялтныг ял эдлүүлэх", 118-р зүйл, 127-р зүйл үүнд хамаарна.

⁹ Тухайлбал: хуулийн 10-р зүйл, 14-24-р зүйл болон бусад зүйл, хэсэгт

¹⁰ Тухайлбал: хуулийн 9-р зүйл, 11-13-р зүйл болон бусад зүйл, хэсэгт.

¹¹ Тухайлбал: хуулийн 6-р зүйл, 7-р зүйл, 8-р зүйл, 12-19-р зүйл, 21-24-р зүйл, 31-р зүйл, 34-р зүйл, 44-р зүйл болон бусад зүйл, хэсэгт.

¹² Тухайлбал: хуулийн 20-р зүйл, 25-30-р зүйл, 35-39-р зүйл, 41-43-р зүйл, 45-58-р зүйл болон бусад зүйл, хэсэгт.

¹³ Тухайлбал: хуулийн 18-21-р зүйл болон бусад зүйл хэсэгт.

хуульд "ялтан"¹⁴, "хоригдол"¹⁵, 2002 оны хуульд "ялтан"¹⁶ гэсэн нийтлэг нэр томъёотой хамт "18 насанд хүрээгүй хоригдол", "насанд хүрээгүй хоригдол", "насанд хүрээгүй /эрэгтэй, эмэгтэй/ ялтан" гэсэн нэр томъёог хэрэглэж ирсэн.

2. Салбарын үе үеийн хуульд¹⁷ насанд хүрээгүй ялтан /хоригдол/-д оногдуулсан хорих ялыг насанд хүрэгсдээс тусгаарлан эдлүүлэх зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага 1994 оныг хүртэл "Хүмүүжил-хөдөлмөрийн колони", 1994 оны 01-р сараас өнөөг хүртэл "Насанд хүрээгүйчүүдийн хорих анги" гэж нэрлэгдэж байна¹⁸.

Гэхдээ 1966 оны хуулийн дагуу тэднийг хүмүүжил-хөдөлмөрийн жирийн дэглэмтэй колонид, онц аюултай гэмт хэрэг үйлдэгсдийг дээрх дэглэмийн дотор чангалсан салбарт, 1982 оны хуулийн дагуу хүмүүжил-хөдөлмөрийн колоний, 2002 оны хуулийн дагуу насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн жирийн, чанга дэглэмд тусгаарлан ял эдлүүлж байна.

¹⁴ Тухайлбал: хуулийн 60-63-р зүйлд "ялтан", "засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялтан", "тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан ялтан", 66-67-р зүйлд "тэнсэгдсэн ялтан", 68, 69-р зүйлд "хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтан" гэх мэт.

¹⁵ Тухайлбал: хуулийн 78-100-р зүйл болон бусад зүйл, хэсэгт.

¹⁶ Тухайлбал: хуулийн 115, 117-122-р зүйл болон бусад зүйл, хэсэгт.

¹⁷ Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай 1931 оны салбарын анхны хуульд энэ талаар тусгайлсан хэм хэмжээ /нэр томъёо/ байхгүй бөгөөд одоогоор насанд хүрээгүй хүнийг хорьж ялыг нь эдлүүлж байсан эрх зүйн зохицуулалт, практикийн талаар бүтээлүүдэд дурьдаагүй байна.

¹⁸ Энэ нь нэр томъёоны төдийгүй мөн чанар-чиг үүргийн хувьд ялгаатай байгууллага болно.

3. Насанд хүрээгүй ялтан /хоригдол/-ы эрх, үүрэг, урамшуулал, сахилгын шийтгэлтэй холбогдсон харилцаа салбарын хуульд бусад ялтантай нэгтгэгдэн нийтлэг хэм хэмжээний түвшинд журамлагдаж байсны зэрэгцээ Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1966 оны хуульд "хоригдож байгаа нөхцлийг өөрчлөх" тусгай зохицуулалтыг зөвхөн насанд хүрээгүй ялтанд урамшууллын журмаар нэмж¹⁹ хэрэглэхээр тусгасан.

Мөн 1966 оны хуульд үлгэр жишээчээр засарч хүмүүжиж, хөдөлмөрт үнэнч шударгаар хандаж байгаа насанд хүрээгүй хоригдолд урамшууллын журмаар сард нэг удаа түр, удаан хугацааны уулзалтын аль нэгийг, мөн эргэлт илгээлт авахыг²⁰, Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1982 оны хуульд дээрх зан төлөв болон ялын тодорхой хувийг эдэлсэн тохиолдолд хүнсний бүтээгдхүүн, нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авах мөнгө нэмж зарцуулах, түр хугацааны нэмэгдэл уулзалт хийхийг зөвшөөрсөн зохицуулалт²¹ байсан.

4. Хүмүүжил-хөдөлмөрийн колоний захиргаа 1982 оны 7-р сарын 01 хүртэл хугацаанд Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисстой зөвшилцөн уламжилж шүүх магадлал гарган, харин энэ үеэс 1994 оны 01-р сарын 01 хүртэл хугацаанд колоний дарга Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисстой тохиролцон

¹⁹ Хуулийн 20-р зүйл //А.Лхагваа "Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж: хууль, эрх зүйн баримт бичиг, харьцуулсан судлал" УБ.2013 он, 48 дах тал

²⁰ Дурьдсан эх сурвалжийн 54 дах тал, холбогдох хуулийн 33-р зүйл.

²¹ Дурьдсан эх сурвалжийн 91, 92 дах тал, холбогдох хуулийн 71, 72-р зүйл.

прокурорын зөвшөөрөлтэйгээр тогтоол гарган, 1994 оноос өнөөг хүртэл хорих ангийн даргын шийдвэрээр насанд хүрээгүй ялтныг салбарын хуульд заасан үндэслэлээр²² 2 жил буюу 20 нас хүртэл нь хорих ялыг тухайн байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх зохицуулалт үйлчилж байна.

5. Харин 18 насанд хүрсэн ялтныг засан хүмүүжүүлэх-хөдөлмөрийн колони /1994 оныг хүртэл/, насанд хүрэгсдийн хорих ангид шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэж ирсэн.

6. 1994 оноос насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмд ял эдэлж буй ялтан тоон хязгаарлалтгүйгээр түр уулзалт, илгээмж авах болон жилд 8 удаа удаан хугацааны уулзалт, чанга дэглэмд ял эдэлж буй бол 1 сард 1 удаа түр, 2 сард 1 удаа удаан хугацааны уулзалт хийж, 1 сард 1 илгээмж авах зохицуулалт бий болсон.

II

Эрдэм шинжилгээний нийтлэлийн зорилготой холбогдуулан насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх, тэдний эрхийг хамгаалахтай холбогдсон олон улсын гэрээний болон ОХУ, Казахстан улсын

Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн²³ онцлох, анхаарал хандуулах нь зүйтэй хэмээн судлаачдаас үзэж буй зарим зохицуулалтын талаар товч үзье. Энэ нь:

Нэг. Олон улсын эрх зүйн зохицуулалт

а/ Хүүхдийн эрхийн тухай конвенцийн²⁴

-Оролцогч улсууд конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоох, захиргааны болон бусад бүх арга хэмжээг авна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээг нөөц бололцоондоо тулгуурлаж дээд зэргээр ашиглах, шаардлагатай бол олон улсын хамтын үйл ажиллагааны хүрээнд авна. /4-р зүйл/

-хүүхэд эцэг, эхтэйгээ харилцаа холбоотой, тэдний талаар мэдээлэлтэй байх. /9-р зүйл 3, 4 хэсэг, 10-р зүйл/

-эцэг, эх, тодорхой тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчид хүүхдийн хүмүүжил, хөгжилд гол хариуцлагыг хүлээнэ. /18-р зүйл 1 хэсэг/

-Оролцогч улс таван жил тутам конвенцоор хүлээн зөвшөөрсөн эрхийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшлийн талаархи тайланг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Хүүхдийн эрхийн асуудал эрхэлсэн хороонд ирүүлэх үүрэгтэй. /44-р зүйл "б"/

²² Тухайлбал: 1966 оны хуулийн 34-р зүйлд зааснаар "... 18 насанд хүрсэн хоригдлыг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид шилжүүлэх явдал хэрэв түүнийг ерөнхий боловсролын ба техник мэргэжлийн сургалтыг дуусгахад саад болно гэж үзвэл шүүх магадлал гаргаж....", 1982 оны хуулийн 74-р зүйлд зааснаар "... 18 насанд хүрсэн ялтан засарч хүмүүжих замд баттай орсон бол засарч хүмүүжсэн үр дүнг бататгах; ерөнхий боловсрол, мэргэжил олгох сургалтыг дуусгах зорилгоор", 1993 оны хуулийн 23-р зүйлийн 4 дэх хэсэг, 1996 оны хуулийн 82-р зүйлийн 5 дэх хэсэгт зааснаар "... Хоригдлын ялын хугацаа, хувийн байдлыг харгалзан...", 2002 оны хуулийн 110-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар "... ялтны хувийн байдал, ял эдэлсэн хугацааг харгалзан

²³ Орос хэлнээ "Уголовно-исполнительный кодекс" гэж бичсэнийг "Эрүүгийн ял эдлүүлэх /гүйцэтгэх/ хууль" хэмээн монгол хэлнээ хөрвүүлэв. //нийтлэл бичигч

²⁴ Манай улс энэ конвенцид 1990 оны 01-р сарын 26-ны өдөр гарын үсэг зурж, 1990 оны 7-р сарын 05-ны өдөр соёрхон баталсан. //Төрийн мэдээлэл. Тусгай дугаар, I боть. УИХ-ын Тамгын Газар, Гадаад хэргийн яам, УБ.2004 он.

-Оролцогч улс тайланг өөрийн улсын олон нийтэд өргөнөөр хүртэхүйц бололцоогоор хангана./44-р зүйл 6 хэсэг/

*б/ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдийн*²⁵

-Хоригдол эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хорих газраас гарч явах онцгой тохиолдолд түүнд өөрийнхөө хувцсыг эсвэл нүдэнд өртөхөөргүй бусад хувцсыг өмсөхийг зөвшөөрөх нь зүйтэй. /17.3 хэсэг/

-Насанд хүрээгүй хоригдлуудад ... тоглох, боломжийн дасгал хийх явдлыг хангавал зохино. Үүний тулд талбай, тоноглол, төхөөрөмжтэй байвал зохино. /21.2 хэсэг/

-Бүх хорих байгууллага өөрийн мэдэлд ядахдаа 1 сэтгэц судлалын зохих мэдлэгтэй эмнэлгийн мэргэжлийн ажилтантай байх ёстой. /22.1 хэсэг/

-Хоригдол бүр мэргэжлийн шүдний эмчид үзүүлж эмчлүүлэх боломжтой байх ёстой. /22.3 хэсэг/

в/ НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн талаархи

*байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрмүүдийн*²⁶
/Бээжингийн дүрмүүд/

²⁵ 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын "Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаарх" 1-р хурлаар баталж, Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1957 оны 7-р сарын 31-ны 663 C/XXIY, 1977 оны 5-р сарын 13-ны 2076 /LXII/ тогтоолд сайшаав. //Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан "Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл" УБ.2014 он. Монгол Улсын ХЭҮК, Каритас Чех Байгуулга. х.78-88.

²⁶ Милан хотноо 1985 оны 8-р сарын 25-наас 9-р сарын 06-ны хооронд болсон НҮБ-ын Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаарх 7-р их хурлаар батлуулахаар өргөн барьж Ерөнхий Ассемблейн 1985 оны 11-р сарын 29-ний 40/33 тогтоолоор баталсан. //Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл: эргүүгийн эрх зүй, эргүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Эрхлэн эмхэтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбоо УБ.2012 он, х.131-154.

-Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллагын хүмүүжлийн ажлын гол зорилго нь халамж, хамгаалалтаар хангах, нийгэмд ашигтай, нийгэмд үр бүтээлтэй үүрэг биелүүлэхэд нь боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгоход чиглэгдэнэ. /26-р зүйлийн 26.1/

-Засан хүмүүжүүлэх байгууллагаас хугацааны өмнө тэнсэн суллах явдлыг зохих байгууллагаар аль болох боломжийн өргөн хүрээнд ял эдлэлтийг аль болох боломжийн эхний хугацаанд хэрэглэх ёстой. /28-р зүйлийн 28.1/

*г/ Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмуудын*²⁷

-Хорих ял эдэлж буй хүмүүст ... нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцлийг бий болговол зохино. /10-р зүйл/

*д/ Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан журмын*²⁸

-Засаг төрийн эрх хэмжээ бүхий байгууллага ... насанд хүрээгүй хүмүүс болон орон нутгийн оршин суугчдын хооронд чөлөөтэй холбоо хэлхээг урамшуулсан идэвхитэй алхамыг хэрэгжүүлж байх ёстой./Хавсралт хэсгийн 8-р зүйл/

- ... Засан хүмүүжүүлэх байгууллагад насанд хүрээгүй хүний ... эрүүл мэнд, өөрийгөө хүндэтгэх явдалд дэмжлэг үзүүлэх, өөрийг нийгмийн гишүүн болгох боломжийг хөгжүүлэхэд туслахуйц тийм үзэл бодол, дадал

²⁷ НҮБ-ын Ерөнхий ассемблейн 1990 оны 12-р сарын 14-ны 45/111 тогтоолоор баталсан. //25-р ишлэлд дурьдсан эх сурвалж. х.88-89.

²⁸ НҮБ-ын Ерөнхий ассемблейн 1990 оны 12-р сарын 14-ны 68-р хуралдаанаар хэлэлцсэн. //Дурьдсан эх сурвалж. х.118-136.

зуршлыг төлөвшүүлэх явдлыг урамшуулах, тэднийг хариуцлагаа мэдэрдэг болгон хүмүүжүүлэхэд тус дөхөм болсон үр нөлөөтэй арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” /Хавсралт хэсгийн 12-р зүйл/

-Насанд хүрээгүй хүмүүсийн хувьд засан хүмүүжүүлэх байгууллагыг нээлттэй байгуулах ёстой. Нээлттэй засан хүмүүжүүлэх байгууллагад аюулгүй байдлын арга хэмжээ байхгүй буюу хязгаарлагдмал байна. Хаалттай засан хүмүүжих байгууллагад байгаа насанд хүрээгүй хүмүүсийн тоо хүмүүжлийн ганцаарчилсан арга хэрэглэх боломжтой байлгах үүднээс цөөн байлгах ёстой. Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллага нь төвлөрсөн бус, насанд хүрээгүй хүмүүс ба тэдний гэр бүлийн хоорондын хэлхээ холбоог тасалдуулахгүй байх хэмжээнд байна./Хавсралт хэсгийн 30-р зүйл/

-Насанд хүрээгүй хүнийг гадаад ертөнцтэй зохих ёсны холбоо хэлхээгээр хангах бүхий л хэрэгслийг ашиглах нь хүнтэй шударга, хүмүүнлэг харьцах эрхийн салшгүй хэсэг болдог бөгөөд тэднийг нийгэмд буцаан оруулахад бэлтгэхэд нэн чухал ач холбогдолтой. Насанд хүрээгүй хүмүүс гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүс, нэр хүндтэй, найдвартай байгууллагын төлөөлөгчидтэй харилцах, гэртээ очих, гэр бүлийнхэнтэйгээ уулзахаар засан хүмүүжүүлэх байгууллагаас гаргах, боловсрол, мэргэжил эзэмших, бусад нэн чухал зорилгоор засан хүмүүжүүлэх байгууллагаас гарч явах боломжоор хангагдах ёстой. Ял эдэлж байгаа хүмүүс засан хүмүүжүүлэх байгууллагаас гадуур байсан хугацааг ялыг хугацаанд оруулан тооцно. /Хавсралт хэсгийн 59-р зүйл/

-“ ... Ямарч тохиолдолд хоол ундыг хасах, гэр бүлийн гишүүнтэйгээ уулзахыг хязгаарлах буюу хориглох явдал байж болохгүй ...”/хавсралт хэсгийн 67-р зүйл/

-“ ... Бүх ажилтнууд ... засан хүмүүжүүлэх байгууллагын дотоод ба түүний гаднах амьдралын ялгааг аль болохоор бууруулахыг эрмэлзэх ёстой” /Хавсралт хэсгийн 85-р зүйл “f”/

Хоёр. ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн дагуу²⁹

а/ Хорих ялаар шийтгэгдсэн насанд хүрээгүй хүн хүмүүжлийн колонид ял эдлэх ба тэднийг энд 19 нас хүртэл нь прокурорын зөвшөөрлөөр хүмүүжлийн колоний даргын тогтоолоор үлдээж болно³⁰.

Харин хорих ялыг эдлэх хугацаандаа 18 насанд хүрсэн, зан байдлын хувьд сөрөг хандлагатай ялтныг хэрвээ хүмүүжлийн колони дотор засан хүмүүжүүлэх жирийн дэглэмтэй колоний адил дэглэм бүхий тусгаарласан хэсэг байвал тэнд³¹, эсхүл жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх колонид ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу шүүхийн шийдвэрээр шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ³².

б/ Хэрэв гяндангаас бусад³³ насанд хүрэгсдийн засан хүмүүжүүлэх

²⁹ Энэ хуулийг Төрийн дум 1996 оны 12-р сарын 18-нд баталж, Холбооны Зөвлөл 1996 оны 12-р сарын 25-нд хэлэлцэн дэмжсэн ба түүний 1-р зүйлд заасны дагуу 1997 оны 7-р сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болж үйлчилж байна. //http://uikodeks.ru

³⁰ Хуулийн 74-р зүйлийн 9 хэсэг, 139-р зүйлийн 1, 3 хэсэг //Дурьдсан эх сурвалж

³¹ Хуулийн 140-р зүйлийн 1 хэсэг, 139-р зүйл 2 хэсэг //Энэ тохиолдолд тэдний хорих ял эдлэх нөхцөл, хоол хүнс, материал ахуйн хангалт насанд хүрээгүй ялтантай адил байна

³² Хуулийн 140-р зүйл 2 хэсэг

³³ Гяндан ял эдлэх нөхцлөөр ердийн, чанга гэж хуваагдана. Хуулийн 87-р зүйл 2 хэсэг

колоний нэг дэглэмийн дотор хорих ялыг эдлэх ердийн, хөнгөвчилсөн, хатуу /чанга/³⁴ нөхцөл байдаг бол хүмүүжлийн колонид ердийн, хөнгөвчилсөн, хөнгөн, хатуу гэсэн 4 нөхцөл бий³⁵.

Хорих ял эдлэх нөхцөл нь ялыг ялгамжтай эдлүүлэх, ялтны зэрэг зан үйлийг урамшуулан дэмжих, засан хүмүүжүүлэх байгууллагаас суллахад бэлтгэх чиг үүрэгт захирагдах ба ялтны эрхийн хязгаарлалттай холбогддог³⁶.

³⁴ Орос хэлнээ "строгие условия отбывания наказания" гэж бичснийг "ял эдлэх хатуу нөхцөл" гэж цаашид хөрвүүлэн хэрэглэнэ./нийтлэгч

³⁵ Хуулийн 132-р зүйл 1 хэсэг. Мөн зүйлийн 2-р хэсэгт "ердийн нөхцөлд", 3-р хэсэгт "хатуу нөхцөлд" хорих ял эдлэх насанд хүрээгүй ялтны талаар, 4-р хэсэгт "ердийн нөхцлөөс хөнгөвчилсөн нөхцөлд", 5-р хэсэгт "хөнгөвчилсөн нөхцлөөс хөнгөн нөхцөлд", 6-р хэсэгт "ердийн нөхцлөөс хатуу нөхцөлд", 7-р хэсэгт "хөнгөвчилсөн нөхцлөөс ердийн, хатуу нөхцөлд", 8-р хэсэгт "хөнгөвчилсөн нөхцлөөс ердийн нөхцөлд" шилжих тохиолдлыг хуульчилжээ.

³⁶ Хуулийн 132,

133-р зүйл. Хүмүүжлийн колонид хорих ял эдлэх нөхцөл ЖНб: Ердийн нөхцөлд хорих ял эдэлж буй насанд хүрээгүй хүн сард хүнсний бүтээгдхүүн, нэн хэрэгцээт зүйлсийг худалдан авахад нэрийн дансаасаа 4000 рублийг зарцуулах, жилд 8 удаагийн түр, 4 удаан хугацааны уулзалт хийх эрхтэй бол хөнгөвчилсөн нөхцөлд ял эдлэгсэд ... сард 6000 рубль ... зарцуулах, жилд 12 удаагийн түр, 4 удаан уулзалт, хөнгөн нөхцөлд ... хязгаарлалтгүйгээр ... нэрийн дансны мөнгөө зарцуулах, ...түр уулзалт хийх, жилд 6 удаан хугацааны уулзалтыг хүмүүжлийн колоний нутаг дэвсгэрийн гадна (хоноглож) хийх эрх эдэлнэ. Тэрчлэн хүмүүжлийн колоний даргын тогтоолоор хөнгөн нөхцөлд ял эдэлж буй насанд хүрээгүй хүнд колоний нутаг дэвсгэрийн гадна харуул хамгаалалтгүйгээр, захиргааны хяналтын дор нийтийн байранд амьдрахыг зөвшөөрч болно. Энэ нөхцөлд тэдэнд бэлэн мөнгө ашиглах, энгийн хувцас хэрэглэхийг зөвшөөрдөг. Хатуу нөхцөлд ял эдлэгсэд сургалт, ажлаас бусад цагт тусгаарласан хаалттай /цоожтой/ байранд ял эдлэх бөгөөд тэдэнд сард ... 3000 рубль зарцуулах, жилд 6 удаагийн түр уулзалт авахыг зөвшөөрдөг.

в/ Нийт ялтанд хэрэглэдэг урамшууллын арга хэмжээ³⁷-нээс гадна хорих ял эдэлж буй насанд хүрээгүй хүнд соёл, урлаг-уран сайхны болон спортын арга хэмжээг хүмүүжлийн колоний ажилтантай хамт үзэх, эцэг, эх тэднийг орлох болон ойрын төрөл садангийн хүнтэй хүмүүжлийн колониос гадагшаа гарах эрх олгох, хугацааны өмнө хорих ял эдлэх хатуу нөхцлөөс ердийн нөхцөлд шилжүүлэх урамшууллыг үзүүлдэг³⁸.

г/ Зөрчил гаргасан насанд хүрээгүй ялтанд оногдуулах сахилгын арга хэмжээ мөн өөрийн онцлогтой. Тодруулбал: ял эдлэх тогтоосон журам зөрчсөн тохиолдолд тэдэнд донгодох, 200 хүртэл рублийн сахилгын торгууль оногдуулах³⁹ болон уран сайхны кино үзэх эрхийг 1 сарын хугацаагаар хасах, хичээл сургалтад оролцуулан сахилгын тусгаарлах байранд 7 хүртэл хоног хорих гэсэн сахилгын шийтгэл оногдуулна⁴⁰.

д/ Хорих ял эдэлж буй ялтанд 4 цаг үргэлжлэх түр, 3 өдөр үргэлжлэх удаан хугацааны уулзалтыг засан хүмүүжүүлэх байгууллагын нутаг дэвсгэрт олгож болно. Энэ хуулинд заасан тохиолдолд ялтанд засан хүмүүжүүлэх байгууллагаас гадуур 5 өдөр үргэлжлэх удаан хугацааны уулзалтыг олгож болно. Энэ тохиолдолд засан хүмүүжүүлэх байгууллагын дарга уулзалтын журам, уулзалт явагдах газрыг тодорхойлно.

е/ Хүмүүжлийн колонид ял эдлэгсэд өөрийн хүсэлтээр удаан

³⁷ Хуулийн 113-р зүйл

³⁸ Хуулийн 134-р зүйл. Мөн урамшуулал олгох журам нь хуулийн 135-р зүйлд тодорхойлогдсон.

³⁹ Хуулийн 115-р зүйлийн 1-р хэсгийн "а", "б" заасан./Энэ нь насанд хүрсэн ялантай адил болно.

⁴⁰ Хуулийн 136-р зүйл

хугацааны уулзалтыг колоний гадна хийх түр уулзалтаар болон нийт ялтны адил утсаар ярих явдлаар солихыг зөвшөөрнө⁴¹.

ё/ Хүмүүжлийн колоний амьдралын бүсийн нэг ялтанд ноогдох талбй 3,5 м² –ээс бага байх ёсгүй⁴².

ж/ Ажил хөдөлмөр эрхлэж буй насанд хүрээгүй ялтан жил тутам 18 ажлын өдрийн, хуульд заасан бусад тохиолдолд 24 хүртэл ажлын өдрийн цалинтай амралт эдэлнэ⁴³.

Мөн түүнээс үл хамаарах шалтгаанаар ажлаар хангагдаагүй ялтанд жил тутмын цалинтай амралттай тэнцүү хоногоор засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагшаа явахыг зөвшөөрч болно⁴⁴.

з/ Хууль зүйн туслалцаа авахад нь зориулан хорих ял эдлэгсдэд өмгөөлөгчтэй болон хууль зүйн зөвөлгөө үзүүлэх эрх бүхий бусад хүмүүстэй уулзахад нь 4 хүртэл цагийн уулзалтыг тоон хязгаарлалтгүйгээр олгоно. Ялтны хүсэлтээр өмгөөлөгчтэй хийх уулзалтыг гуравдагч хүн сонсохооргүй болон техникийн чагнах төхөөрөмжгүй газарт ганцаарчлан явуулна⁴⁵.

и/ Хорих ял эдлэгсдийн хувийн онцгой нөхцөл байдал (ойрын төрөл садангийн хүн нас барсан эсхүл амь насанд аюултайгаар өвчилсөн, байгалийн гамшигийн улмаас ялтан болон түүний гэр бүлд материалын үлэмж хохирол учирсан), тэрчлэн суллагдсаны дараах ажил хөдөлмөр эрхлэх, амьдрах орон байрны асуудлаа урьдчилан шийдвэрлэхтэй нь

холбогдуулан явах, ирэх зам хоногийг оролцолгүйгээр засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагшаа 7 хүртэл хоногийн хугацаагаар явахыг тэдэнд зөвшөөрч болно⁴⁶.

Засан хүмүүжүүлэх байгууллагаас ийнхүү гадагшаа гарахыг насанд хүрээгүй ялтны хувьд гэр бүлийн хүмүүс эсхүл бусад дагалдан явах хүмүүсийн хамт зөвшөөрнө⁴⁷.

Гурав. Казахстан улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн⁴⁸

хорих ял шийтгэгдсэн насанд хүрээгүй этгээдийн харьцаанд тогтоосон журам нь ерөнхийдөө ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн холбогдох зохицуулалттай адил⁴⁹ боловч түүний дараах онцлогыг тодотгож болно. Энэ нь:

а/ Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ялыг эдлэх байгууллагыг “Насанд хүрээгүйчүүдийг хорих аюулгүй байдлын дунд түвшиний байгууллага” гэж нэрлэдэг ба тэрээр бие даасан хорих байгууллагын төрөл мөн⁵⁰.

⁴⁶ Хуулийн 97-р зүйл 1 хэсэг “а”

⁴⁷ Хуулийн 97-р зүйлийн 4 хэсэг.

⁴⁸ Энэ хууль 2014 оны 7-р сарын 05-ны өдөр батлагдсан ба 2015 оны 01-р сарын 01-ны өдрөөс үйлчилж эхэлсэн
http://online.zakon.kz/document/?doc_id=31577723 //2015 оны 5-р сарын 31-ны өдрийн нийтлэгчийн хандалт

⁴⁹ Тухайлбал: насанд хүрээгүй ялтны хорих ял эдлэх байгууллага нь нөхцлөөр хатуу, ердийн, хөнгөвчилсөн, хөнгөн гэж хуваагдана /150-р зүйл/, мөн тэдэнд хэрэглэх урамшууллын арга хэмжээ /152-р зүйл, 153-р зүйл/, түр, удаан хугацааны уулзалт, чөлөө зэрэг.

⁵⁰ Хуулийн 89-р зүйл 1 хэсэгт зааснаар хорих ял эдлүүлэх байгууллага нь: 1) Аюулгүй байдлын бага түвшиний байгууллага, 2) Аюулгүй байдлын дунд түвшиний байгууллага, 3) Насанд хүрээгүйчүүдийг хорих аюулгүй байдлын дунд түвшиний байгууллага, 4) Аюулгүй байдлын дээд түвшиний байгууллага, 5) Аюулгүй байдлын онцгой түвшиний байгууллага, 6) Бүрэн аюулгүй

⁴¹ Хуулийн 89-р зүйл 3 хэсэг

⁴² Хуулийн 99-р зүйл 1 хэсэг

⁴³ Хуулийн 104-р зүйл 4 хэсэг, 5 хэсэг

⁴⁴ Хуулийн 97-р зүйлийн 1 хэсэг “б”

⁴⁵ Хуулийн 89-р зүйлийн 4 хэсэг.

б/ Хэрэв ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн дагуу энэ улсад хорих ял эдэлж буй насанд хүрээгүй хүнд тоон хязгаарлалтгүйгээр илгээмж, гуйвуулга авахыг зөвшөөрдөг бол Казахстан улсын хувьд ердийн нөхцөлд ял эдэлж буй насанд хүрээгүй ялтан жилд 10, хөнгөвчилсөн нөхцөлд-14, хатуу нөхцөлд- тус бүр 6 илгээмж, гуйвуулга авах, мөн хөнгөн нөхцөлд – тоон хязгаарлалтгүй удаан хугацааны уулзалт, хатуу нөхцөлд- жилд 2 удаагийн удаан хугацааны уулзалт, тус бүр 6 илгээмж, гуйвуулга авахыг зөвшөөрдөг⁵¹.

в/ Ял эдлэх тогтоосон журам зөрчсөн тохиолдолд хорих ялыг эдэлж буй насанд хүрээгүй хүнд **сануулах**, донгодох, **хатуу донгодох**, **72 цаг хүртэл хугацаагаар түр тусгаарлах байранд хорих** сахилгын шийтгэл хүлээлгэнэ⁵².

Мөн хуулийн 154-р зүйлийн 2 хэсэгт ял эдлэх тогтоосон журмын ноцтой зөрчилд тооцох насанд хүрээгүй ялтны үйлдэл, эс үйлдэхүйг журамлаж өгсөн. Энэ нь:

1) Байгууллагыг тохижуулах, амьдрах нөхцлийг сайжруулах ажил хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзах;

2) Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх;

3) Байгууллагын захиргааны төлөөлөгчдийг заналхийлэх, доромжлох, тэдэнд захирагдахгүй байх болон ял эдлэх дэглэм зөрчих

зорилгоор санаатайгаар биедээ ямар нэгэн гэмтэл учруулах;

4) Байгууллагын дотоод журамд тусгагдаагүй эд зүйлс, баримт бичиг, хэрэгсэл, бодис, хүнсний зүйлийг олж авах, дамжуулах, бэлтгэх, хадгалах;

5) Материаллаг болон бусад ашиг олох зорилгоор хөзөр, мөрийтэй бусад тоглоом тоглох;

6) Шүүхээс тогтоосон зайлшгүй болон албадлагын эмчилгээнээс зайлсхийх;

7) Сексийн шинжтэй үйлдэл хийх;

8) Энэ хэсгийн 1-7 дэд хэсэгт заасан зөрчил гаргахад чиглэсэн ялтны бүлэглэлийг зохион байгуулах эсвэл түүнд оролцох.

г/ Насанд хүрээгүйчүүдийг хорих аюулгүй байдлын дунд түвшиний байгууллагад 18 нас хүрсэн ялтныг тэдний саналыг авч 21 нас хүртэл нь байлгаж болох ба үүнийг байгууллагын даргын тодорхойлолтын үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ⁵³.

III

Энэ цаг үед Засгийн газраас санаачилан УИХ-аар хэлэлцэж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн шинэчилсэн найруулгын төсөл⁵⁴ дэх насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлог нь:

а/ Уг харилцааг төслийн “Өсвөр насны ялтныг ял эдлүүлэх” гэсэн 109-р зүйл болон бусад нийтлэг зүйл-хэсгийн түвшинд⁵⁵ журамласан.

⁵³ Хуулийн 155-р зүйл

⁵⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл //Эмхэтгэсэн: Хууль зүйн яам, хянасан: Ч.Батэрдэнэ, Д.Амгалан, хэвлэсэн газар: ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, хэвлэсэн он, сар: 2015 оны 5-р сар.

⁵⁵ Тухайлбал: 112-р зүйл.Оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, 114-р зүйл. Ялтны эрх,

байдлын байгууллага, 7) Аюулгүй байдлын холимог түвшиний байгууллага гэж хуваагдана. //дурьдсан эх сурвалж

⁵¹ Хуулийн 151-р зүйл

⁵² Хуулийн 154-р зүйл 3 хэсэг

б/ Төсөлд мөн зарчмын шинжтэй дараах шинэ зохицуулалт орсон. Тухайлбал:

-өсвөр насны ялтны ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлэх /Төслийн 109-р зүйлийн 109.1 хэсэг/⁵⁶.

-18 насанд хүрсэн ялтныг сургалт хүмүүжлийн байгууллагад үргэлжлүүлэн 3 жил хүртэл хугацаагаар үлдээж болох. Гэхдээ шийдвэр гаргах эрх өнөөгийн хуулийн зохицуулалтын адил байгууллагын даргад хадгалагдсан. /Төслийн 109-р зүйл 109.4 хэсэг/

-Өсвөр насны ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй гэсэн нь өнөөгийн хуулийн зохицуулалттай адил, харин удаан хугацааны уулзалт 8-аас дээш удаа хийж болох. /Төслийн 109-р зүйл 109.5 хэсэг/

-Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын харуул хамгаалалт, орчин нөхцөл, дотоод журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоох. /Төслийн 109-р зүйлийн 109.6 хэсэг/

в/ Ялтан 18 насанд хүрмэгц ялыг нь эдлүүлэхээр насанд хүрэгсдийн хорих ангид шилжүүлэх асуудлаар сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал

гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ гэж төслийн 109-р зүйлийн 109.3-д заасан нь үндсэндээ өнөөдөр үйлчилж буй хуулийн зохицуулалт /110-р зүйлийн 110.3 хэсэг/, хууль зүйн практиктай адил болсон.

Дүгнэлт-санал

Монгол Улсын Засгийн газраас санаачлан УИХ-аар энэ цаг үед хэлэлцэж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл агуулга, найруулга, хэлбэрийн хувьд "дүн нуруугаараа" олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээ, хөгжлийн чиг хандлагатай нийцсэн, гадаадын зарим орнуудын дэвшилттэй, манай нөхцөл байдал, амьдралын шаардлагатай уялдсан зарчмын шинэлэг нилээдгүй зохицуулалтыг өөртөө агуулсан боловч бидний үзэж байгаагаар түүний "хорих ялаар шийтгүүлсэн насанд хүрээгүй хүний ялыг эдлүүлэх институци"-д өөрчлөх шаардлагатай цөөнгүй хэм хэмжээ байна. Энэ нь:

1. Төсөлд өнөөгийн хуулийн адил салбарын өмнөх хуулиудын /ялангуяа Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1966, 1982 оны/ уламжлалт, дэвшилтэт зарим зохицуулалт⁵⁷ орхигдсон.

2. Мөн төслийн зарим зохицуулалт ялтны дахин нийгэмших⁵⁸,

үүрэг, 11-р зүйл. Ялтныг тусад нь ял эдлүүлэх, 118-р зүйл. Ялтан бусадтай уулзах, харилцах, 124-р зүйл. Хорих анги дахь сургалт, 127-р зүйл. Ялтанд хүлээлгэх сахилгын шийтгэл, 128-р зүйл. Ялтны ахуйн нөхцөл, 129-р зүйл. Ялтныг суллах, 130-р зүйл. Ялтныг суллах журам тус тус болно.

⁵⁶ Өөрөөр хэлбэл өнөөгийн хуулиар хорих ялаар шийтгэгдсэн насанд хүрээгүй хүний ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн, чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлж байгаа бол төсөлд өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хорих анги бус сургалт-хүмүүжлийн "дэглэмийн ялгаагүй" тусгай байгууллагад эдлүүлэхээр заажээ.

⁵⁷ Энэ нь урамшууллын журмаар "удаан хугацааны уулзалт авах", мөн "хүнсний бүтээгдхүүн, нэн хэрэгцээт зүйл худалдан авахад зөвшөөрөгдснөөс нэмж нэрийн данснаас мөнгө зарцуулах /ялангуяа энэ хэм хэмжээ 1993 оны хойш хуулиас хасагдан, эрх зүйн дэд актын түвшинд оновчтой бус байдлаар зохицуулагдах болсон/

⁵⁸ Орос хэлний "ресоциализация" гэсэн үгийг ийнхүү хөрвүүлэв. Манай орны эрх зүйн зарим дэд акт, хууль зүйн практикт хэрэглэж буй "ялтныг нийгэмшүүлэх" гэсэн үг хэллэгт бид

зэрэгээр засарч өөрчлөгдөхөд нь сөргөөр нөлөөлөх боломжтой байна. Тухайлбал: Төслийн 127-р зүйлийн 127.1.1-д заасан "сар, улирал, жилд авах түр болон удаан хугацааны уулзалтын тоог бууруулах" зохицуулалт нь өсвөр насны хорих ялтанд ноцтой байдлаар шууд нөлөөлөхгүй боловч хаалттай хорих ангийн "А", "Б", "В" харуул хамгаалалтын зэрэглэлд ял эдэлж буй насанд хүрсэн ялтанд хүндээр тусах магадлал өндөр байгаагийн зэрэгцээ Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан НҮБ-ын журмын хавсралт хэсгийн 8-р зүйлтэй зөрчилдөж байна.

3. Нийтлэлд иш татсан болон гадаадын бусад орнуудын дэвшилтэт, мөн олон улсын эрх зүйн нийтлэг, тусгай зохицуулалтыг төсөлд нэмж тусгах шаардлага байна. Энэ нь юуны өмнө хорих ялаар шийтгэгдсэн өсвөр насны хүнд хэрэглэх урамшууллын, сахилгын шийтгэлийн, хорих ялаас тэнсэн суллах тусгай хэм хэмжээ, мөн удаан хугацааны уулзалтыг түр хугацааны уулзалтаар, утсаар ярихаар солих, техник-технологийг ашиглан уулзалт-ярилцлагыг зохион байгуулах боломж олгох, ял эдэлж буй байгууллагын гадна гарах, чөлөөгөөр явах, хөдөлмөрийн амралт эдлэх, иргэний нийгэмтэй харьцах, холбогдох эрхийг өргөжүүлэх явдал болно.

4. Төслийн боловсруулалтын түвшинг зарим талаар сайжруулах

шүүмжлэлтэй ханддаг. Учир нь ялтан "хүн л юм болохоор" ямар нэг хэмжээгээр нийгэмшсэн, өөрийн гэсэн найз нөхөд, амьдралын орчинтой тул "нийгэмшүүлэх" гэж ярих нь зохимжгүй, харин "дахин нийгэмшүүлэх" буюу амьдралын хэв маяг, нийгэмд сөрөг зан байдлыг нь өөрчлөх, ухааруулах, засан төлөвшүүлэх боломжтой гэж үздэг.

хэрэгтэй. Учир нь хууль зүйн техникийн дүрмийг тэр бүр чадварлаг ашиглаагүйтэй холбогдон төслийн бичвэрийн зарим зүйл-хэсэг монгол хэлний үг зүй-найруулга зүйн "шууд утга", эрх зүйн ерөнхий онолын шаардлагаар авч үзвэл "эрх зүйн хувьд хийдэлтэй" байна.

Тухайлбал: Төслийн 106-р зүйлийн 106.5, 106.6, 106.7 хэсэгт "ялтанд чөлөө олгох" асуудлыг зөвхөн нээлттэй хорих ангийн ялтанд хамруулахаар тусгасан ба өсвөр насны ялтанд оногдуулсан хорих ялыг нээлттэй хорих байгууллагад бус "сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад" эдлэхээр маш тодорхой заасан тул энэ хэм хэмжээг хэрэглэхгүй боломжгүй.

Мөн төслийн 114-р зүйлийн 114.1.6 хэсэгт "утсаар ярих эрх"-ийг нийт хорих ял эдлэгсдэд хамруулан тусгасан боловч өсвөр насны ялтны хувьд түүний нарийвчилсан зохицуулалтыг мөн л орхигдуулсан байна. Гэтэл төслийн 106-р хэсгийн 106.8 хэсэгт уг харилцааны зохицуулалтыг "нээлттэй хорих ангид ял эдлэгсдэд ("ялтан өөрийн зардлаар таксофон ашиглах эрхтэй") хамруулан тусгайлан журамлажээ.

Эдгээр дүгнэлт санал нь зөвхөн нийтлэл бичигчдийн үзэл бодол ба хуулийн төслийн чанар, үр дүнг сайжруулах, хүний, тэр дотроо эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн эрхэд анхааралтай хандан, зэрэгээр засарч өөрчлөгдөхөд туслах, олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид тусгах зорилго агуулж буй тул уншигч, судлаач та бүхэн мэргэн оюун ухаанаар олон талаас нь шүүн тунгааж, мэтгэлзэх биз ээ.